



МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

2018 ОНЫ IV УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Урсгал ба хөрөнгийн данс 2018 оны 4 дүгээр улиралд 705 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 901 сая ам.долларын ашигтай гарснаар нийт төлбөрийн тэнцэл 334 сая ам.долларын ашигтай гарлаа. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн 138 сая ам.доллар байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 136 сая ам.доллараар өсч, харин санхүүгийн дансны ашиг 782 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 3,542 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 5.8 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16% -иар өсч 3,147 сая ам.долларт хүрсэн ба худалдааны тэнцэл 97 сая ам.долларын ашигтай гарсан.

Тодруулбал, экспортын хувьд, зэсийн баяжмалын экспорт 67 сая ам.доллараар (15%), чулуун нүүрсний экспорт 132 сая ам.доллараар (25%) өссөн бол импортын хувьд СИФ нөхцөлөөр тооцсон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 79 сая ам.доллараар (15%), хэрэглээний бүтээгдэхүүний импорт 105 сая ам.доллараар (29%), нефтийн бүтээгдэхүүний импорт 104 сая ам.доллараар (54%) өссөнөөр барааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 224 сая ам.доллараар буурсан.

Үйлчилгээний худалдаа

2018 оны 4 дүгээр улиралд үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 18%-иар буюу 81 сая ам.доллараар өсч 521 сая ам.долларт хүрсэн. Энэхүү алдагдлын өсөлтөд тээврийн үйлчилгээний дансны алдагдал 37 сая ам.доллараар, аяллын үйлчилгээний алдагдал 66 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Анхдагч орлого

Анхдагч орлогын данс 381 сая ам.долларын алдагдалтай гарч алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 27%-иар буюу 142 сая ам.доллараар буурсан.


Тайлант улиралд гадаад бонд үнэт цаасны хүүгийн төлбөрт 84 сая ам.доллар, ногдол ашигт 42 сая ам.доллар, хөрөнгө оруулагчдын зээлийн хүүгийн төлбөрт 108 сая ам.доллар, бусад зээлийн хүүгийн төлбөрт 222 сая ам.доллар болон арилжааны банкууд харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт нийт 4 сая ам.долларыг тус тус төлсөн байна.

Хоёрдогч орлого


Хувийн гуйвуулга болон хандив тусламжийн шугамаар 2018 оны 4 дүгээр улиралд Монгол улс нийт 71 сая ам.долларыг буюу өнгөрсөн оны мөн үеэс 19 сая ам.доллараар их орлогыг хүлээн авчээ. Үүнд:

- Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан мөнгөн гуйвуулга өмнөх оны мөн үеэс 19%-иар, гадаад руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулга 52%-иар тус тус өсч, цэвэр дүнгээр 39 сая ам.долларын орлого хүлээн авчээ.
- Гадаад хандив тусламжийн орлого өмнөх оны мөн үеэс 18 сая ам.доллараар өссөн байна.


Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл



Дүрслэл 2. Барааны худалдаа



Дүрслэл 3. Үйлчилгээний худалдаа



Хүснэгт 1. Хувийн гуйвуулга 2018.IV улирал (мян ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	36,461	55%	▲ 17%	2,522	9%	▲ 57%
Америк	11,191	17%	▲ 34%	4,216	15%	▲ 41%
Хятад	693	1%	▼ -6%	1,045	4%	▼ -47%
Гонг Конг	668	1%	▲ 20%	311	1%	▲ 53%
Англи	660	1%	▼ -73%	1,823	7%	▲ 92%
ОХУ	2,570	4%	▲ 111%	2,866	10%	▲ 8%
Сингапур	716	1%	▲ 23%	1,164	4%	▲ 180%
Швейцарь	1,296	2%	▲ 5x	92	0%	▲ 100%
Герман	1,179	2%	▼ -22%	489	2%	▼ -28%
Япон	1,058	2%	▲ 27%	577	2%	▲ 12%
Бусад	10,033	15%	▲ 69%	12,602	45%	▲ 74%
НИЙТ	66,525	100%		27,706	100%	

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2018 оны 4 дүгээр улиралд Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын дүн 768 сая ам.доллар, хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал 136 сая ам.доллар буюу цэвэр дүнгээр 632 сая ам.долларын орох урсгалтай байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 22 сая ам.доллараар өссөн байна.

Шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг голлох улсаар нь авч үзвэл:

- Канад улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 90 сая ам.доллараар өсч 476 сая ам.доллар,
- Япон улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 73 сая ам.доллараар өсч 107 сая ам.долларт хүрсэн бол,
- Голланд улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 46 сая ам.доллараар буурч 10 сая ам.доллар,
- БНХАУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 29 сая ам.доллараар буурч 23 сая ам.долларын урсгалтай гарсан байна.

Харин эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 2018 оны 4 дүгээр улиралд уул уурхайн салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт өнгөрсөн оны гүйцэтгэлээс бага зэрэг буурсан үзүүлэлттэй байна.

Салбаруудын хөрөнгө оруулалтын хэмжээг харьцуулбал,

- Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт 75 сая ам.доллараар,
- Боловсруулах үйлдвэрлэлийн салбар 32 сая ам.доллараар өсч,
- Бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар 53 сая ам.доллараар,
- Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар 6 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2018 оны 4 дугаар улиралд 449 сая ам.долларын ашигтай гарсан.

Тайлант улирлын голлох ажил гүйлгээг дурдвал:

- Хөгжлийн банк 500 сая ам.долларын бонд гаргаж,
- Засгийн газар Мазаалай, Гэрэгэ, Чингис 1000 зэрэг бондуудын хүүгийн төлбөрт нийт 75 сая ам.доллар,
- ХХБ өөрийн гаргасан бондын хүүгийн төлбөрт 23 сая ам.долларыг эдийн засгийн харьяат буст тус тус төлжээ.

Бусад хөрөнгө оруулалт

Энэ дансанд санхүүгийн дээрх дансуудад үл хамаарах бусад хөрөнгө оруулалтууд болох арилжааны, хөнгөлөлттэй, худалдааны зэрэг бүх төрлийн зээлүүд, бэлэн мөнгө ба харилцах хадгаламжийн дансны эх үүсвэрийг бүртгэдэг.

Тайлант улиралд манай улсад орсон бусад хөрөнгө оруулалтын эх үүсвэр 171 сая ам.долларын гарах урсгалтай байсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал 978 сая ам.доллараар муудсан үзүүлэлт юм. Энэхүү өөрчлөлтөд Засгийн газрын болон арилжааны банкуудын зээлийн ашиглалт буусан, эргэн төлөлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.


Хүснэгт 2. ГШХО, орох урсгал, улсаар (сая ам.доллар)

№	Үзүүлэлт	IV улирал		2018.IV/17.IV	
		Дүн	Хувийн жин	Өөрчлөлт	
1	Австрали	2	0%	2	▲
2	Америк	55	7%	0	▼
3	Англи	13	2%	13	▲
4	БНХАУ	23	3%	-29	▼
5	Герман	0	0%	-26	▼
6	Голланд	10	1%	-46	▼
7	Хонг-Конг	0	0%	-16	▼
8	Канад	476	62%	90	▲
9	Люксембург	0	0%	-17	▼
10	ОХУ	12	2%	12	▲
11	Сингапур	45	6%	-4	▼
12	Солонгос (өмнөд)	8	1%	4	▲
13	Турк	0	0%	0	▼
14	Франц	0	0%	-5	▼
15	Япон	107	14%	73	▲
16	Бусад	18	2%	-29	▼
Нийт		768	100%	22	▲


Хүснэгт 3. ГШХО, орох урсгал, салбараар (сая ам.доллар)

№	Эдийн засгийн салбар	IV улирал		2018.IV/17.IV	
		2017	2018	Өөрчлөлт	
1	Барилга	23	18	-5	▼
2	Боловсрол	0	0	0	▲
3	Боловсруулах үйлдвэрлэл	2	35	32	▲
4	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	135	81	-53	▼
5	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0	0	0	▼
6	Мэдээлэл, холбоо	0	3	3	▲
7	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1	6	4	▲
8	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	24	99	75	▲
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0	1	1	▲
10	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0	21	21	▲
11	Уул уурхай, олборлолт	529	497	-33	▼
12	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	7	1	-6	▼
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	4	5	0	▲
14	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1	0	0	▼
15	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3	1	-2	▼
16	Бусад	17	3	-15	▼
Нийт		746	768	22	▲

Дүрслэл 4. Багцын хөрөнгө оруулалт (сая ам.доллар)



Дүрслэл 5. Бусад хөрөнгө оруулалт



II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2018 оны 4 дугаар улирлын эцэст цэвэр дүнгээр 33,374 сая ам.долларын үлдэгдэлтэй буюу өр төлбөртэй байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын дүн (актив) 6,204 сая ам.доллар байна. Үүний 57%-ийг гадаад валютын албан нөөц, 30%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 8%-ийг шууд хөрөнгө оруулалт, 5%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Харин Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 39,578 сая ам.долларт хүрчээ. Үүний 50%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 37%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 12%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 4%-иар буюу 1,344 сая ам.доллараар өссөн байна. Үүнийг

- Ерөнхий бүтцээр авч үзвэл, гадаад актив 12%-иар буюу 650 сая ам.доллараар, гадаад пассив 5%-иар буюу 1,994 сая ам.доллараар тус тус өссөн,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц 1,909 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын позиц 46 сая ам.доллараар, албан нөөц 534 сая ам.доллараар тус тус өсч, багцын хөрөнгө оруулалтын позиц 78 сая ам.доллараар буурснаар тайлбарлагдаж байна.
- Тайлант улирлын позицийн өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, төлбөрийн тэнцлийн урсгалаар -567 сая, ханшийн өөрчлөлтөөр 28 сая, бусад өөрчлөлтөөр 154 сая, үнийн өөрчлөлтөөр 114 сая ам.доллараар тус тус өөрчлөгджээ.

Шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 54%-ийг буюу 10,759 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 46% буюу 9,197 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь харуулбал:

- Канад улсаас 6,020 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 30%,
- БНХАУ-аас 4,645 сая ам.доллар буюу 23%,
- Сингапур улсаас 1,635 сая ам.доллар буюу 8%,
- Люксембург улсаас 1,414 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 7%-тай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтыг манай улсад тус тус оруулсан байна.

Багцын хөрөнгө оруулалт

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад активын үлдэгдэл 2018 оны 4 дүгээр улирлын эцэст 294 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 10%-иар өссөн бол гадаад пассивын үлдэгдэл 4,884 сая ам.долларт хүрч 1%-иар буурсан үзүүлэлттэй байна.


Актив: Эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл Хонг-Конг 43%, АНУ 17%, Сингапур 10%, Их Британ 6%, Австрали 6%-ийг тус тус эзэлж байна.

Пассив: Эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал АНУ 16%, Их Британ 8%, Люксембург 5%, Сингапур 4%, Хонг Конг 4%, үлдсэн 53% нь хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа учраас хөрөнгө оруулагчийн харьяалах улсыг тодорхойлох боломжгүй байна.


Хүснэгт 4. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2017	12/31/2018	Өөрчлөлт	
			дүн	хувь
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-32,031	-33,374	1,344	4%
I. Гадаад актив	5,553	6,204	650	12%
1. Шууд хөрөнгө оруулалт	495	521	26	5%
2. Багцын хөрөнгө оруулалт	268	294	26	10%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	00	00	00	-140%
4. Бусад хөрөнгө оруулалт	1,782	1,846	64	4%
5. Нөөц актив	3,008	3,542	534	18%
II. Гадаад пассив	37,584	39,578	1,994	5%
1. Шууд хөрөнгө оруулалт	18,020	19,956	1,936	11%
2. Багцын хөрөнгө оруулалт	4,937	4,884	-53	-1%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	00	01	01	-260%
4. Бусад хөрөнгө оруулалт	14,628	14,738	110	1%

Дүрслэл 6. Гадаад актив, пассив



Дүрслэл 7. Шууд ХО-ын үлдэгдэл, 2018 оны 4 дүгээр улирал



Дүрслэл 8. Багцын ХО-ын үлдэгдэл, 2018 оны 4 дүгээр улирал



III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2018 оны 4 дүгээр улирлын эцсийн байдлаар 28,743 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 1,250 сая ам.доллараар өссөн байна.

Улсын салбар: Засгийн газрын гадаад өр 138 сая ам.доллараар буурч 7,183 сая ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 5 сая ам.доллараар өсч 2,030 сая ам.долларт хүрчээ.

Бусад салбар: Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд энэ дүн өнгөрсөн оны мөн үеэс 1,384 сая ам.доллараар өсч 19,530 сая ам.долларт хүрээд байна.

Банкны салбар

Банкны салбарын гадаад өр төлбөрийн үлдэгдэл 2018 оны 4 дүгээр улиралд 2,220 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 26 сая ам.доллараар өсчээ.

Гадаад өрийн 38%-ийг урт хугацаат зээл, 28%-ийг бонд өрийн бичиг, 19%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 15%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат арилжааны зээлийн үлдэгдэл харгалзан 842 сая ам.доллар, 430 сая ам.долларт хүрсэн үзүүлэлттэй байна.

Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өр төлбөр 2018 оны 4 дүгээр улирлын эцэст 17,310 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 1,358 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Салбарын нийт зээлийн 53% буюу 9,197 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.


Хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.

Эдийн засгийн харьяат аж ахуйн нэгжүүдийн гадаадаас хүлээн авсан экспортын барааны урьдчилгаа болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын барааны төлбөрийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 374 сая ам.доллар болсон байна.


Хүснэгт 5. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2017	12/31/2018	өөрчлөлт		* %
			дүн	хувь	
Нийт гадаад өр	27,493	28,743	1,250	5%	100%
I. Засгийн газар	7,321	7,183	-138	-2%	25%
Бонд, өрийн бичиг	3,549	2,946.6	-602	-17%	
Зээл	3,772	4,236	463	12%	
II. Төв банк	2,025	2,030	5	0%	7%
III. Банк	2,194	2,220.2	26	1%	8%
Богино хугацаат	659	757.2	98	15%	3%
Урт хугацаат	1,535	1,463	-72	-5%	5%
IV. Бусад сектор	7,956	8,114	158	2%	28%
Богино хугацаат	666	597	-70	-10%	2%
Урт хугацаат	7,289	7,517	228	3%	26%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	7,996	9,197	1,200	15%	32%

Дүрслэл 9. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 10. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад зээлийн

ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

Үзүүлэлт	IV улирал			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2016	2017	2018	Дүн	2017/16	Дүн	2018/17
I. УРСГАЛ ДАНС	17	-590	-734	-606	-3648%	-144	-24%
Бараа ба үйлчилгээний худалдаа	244	-118	-424	-362	-149%	-305	-258%
Кредит	1,715	1,721	1,867	5	0%	146	8%
Дебет	1,472	1,839	2,290	367	25%	451	25%
1. Бараа	606	322	97	-284	-47%	-224	-70%
1.1 Экспорт Ф.О.Б (кредит)	1,537	1,521	1,622	-16	-1%	101	7%
1.2 Импорт Ф.О.Б (дебит)	931	1,200	1,525	268	29%	325	27%
2. Үйлчилгээ	-362	-440	-521	-78	-21%	-81	-18%
Кредит	178	199	244	21	12%	45	23%
Дебет	540	639	765	99	18%	126	20%
2.1 Тээвэр	-46	-79	-116	-34	-74%	-37	-46%
Кредит	67	80	101	13	19%	21	26%
Дебит	113	159	217	46	41%	58	36%
2.2 Аялал	-73	-85	-151	-13	-18%	-66	-77%
Кредит	50	54	61	5	9%	7	12%
Дебит	122	140	212	17	14%	72	52%
2.3 Бусад үйлчилгээ	-244	-275	-254	-31	-13%	21	8%
Кредит	61	65	83	4	6%	17	26%
Дебит	305	340	337	35	12%	-4	-1%
3 Анхдагч орлого	-263	-523	-381	-260	-99%	142	27%
Кредит	18	19	88	1	7%	69	364%
Дебет	281	542	469	262	93%	-74	-14%
3.1 Ажилчдын цалин	-9	-11	47	-2	-18%	58	541%
3.2 Хөрөнгө оруулалтын орлого	-254	-515	-431	-262	-103%	85	16%
3.3 Бусад	0	3	2	3		-1	-18%
4 Хөйрөгч орлого	36	52	71	16	45%	19	36%
Кредит	66	73	100	7	11%	27	37%
Дебит	30	21	30	-9	-30%	9	41%
Үүнээс: Хувийн гуйвуулга	9	7	18	-1	-16%	10	138%
II. ХӨРӨНГИЙН ДАНС	21	21	29	0	2%	8	39%
1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/бууралт	0	0	0	0		0	
Кредит	0	0	0	0		0	
Дебет	0	0	0	0		0	
2. Хөрөнгийн шилжүүлэг	21	21	29	0	2%	8	39%
Кредит	22	22	29	0	1%	7	33%
Дебет	1	1	0	0	-15%	-1	-75%
Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээлдэг -)	37	-569	-705	-606	-1630%	-136	-24%
III. САНХҮҮГИЙН ДАНС	-153	-1,683	-901	-1,529	-998%	782	46%
Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээлдэг -)	-153	-1,683	-901	-1,529	-998%	782	46%
1. Шууд хөрөнгө оруулалт	-94	-474	-623	-380	-406%	-149	-31%
1.1 Актив	9	17	9	8	84%	-8	-49%
1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	9	17	9	8	84%	-8	-49%
1.1.2 Өрийн хэрэгсэл	0	0	0	0		0	
1.2 Пассив	103	491	632	388	377%	141	29%
1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	-47	358	276	405	862%	-83	-23%
1.2.2 Өрийн хэрэгсэл	150	133	356	-17	-11%	224	169%
2. Багцын хөрөнгө оруулалт	24	-395	-449	-419	-1778%	-54	-14%
2.1 Актив	0	4	9	5	1018%	4	106%
2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	-1	3	18	4	458%	14	436%
2.1.2 Өрийн бичиг	0	1	-9	0	96%	-10	
2.2 Пассив	-24	399	458	423	1764%	58	15%
2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	0	-1	2	-1	-266%	4	307%
2.2.2 Өрийн бичиг	-24	401	455	424	1791%	55	14%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэлүүд	39	0	0	-40	-101%	1	221%
3.1 Актив	-25	-1	0	24	98%	0	48%
3.2 Пассив	-64	0	-1	64	100%	0	-126%
4. Бусад хөрөнгө оруулалт	-122	-813	171	-691	-564%	984	121%
4.1 Актив	-214	-327	6	-114	-53%	333	102%
4.1.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах	-246	-327	2	-81	-33%	329	101%
4.1.3 Зээл	0	2	-2	1	1364%	-3	-217%
4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	32	-2	6	-34	-106%	8	79x
4.1.5.1 Богино хугацаат	32	-2	6	-34	-106%	8	79x
4.1.5.2 Урт хугацаат	0	0	0	0		0	
4.1.5 Бусад авлага	0	0	0	0		0	
4.2 Пассив	-91	486	-165	577	633%	-651	-134%
4.2.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах	100	-9	-34	-109	-109%	-25	-273%
4.2.3 Зээл	-117	522	-164	639	548%	-687	-131%
4.2.3.1 Төв банк	0	0	0	0		0	
4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд	-117	-11	-104	107	91%	-93	-864%
4.2.3.3.1 Богино хугацаат	-43	-49	-29	-5	-13%	20	41%
4.2.3.3.2 Урт хугацаат	-74	38	-75	112	151%	-113	-299%
4.2.3.2 Засгийн газар	125	581	255	456	366%	-326	-56%
4.2.3.4 Бусад салбар	-124	-48	-315	76	62%	-267	-561%
4.2.3.4.1 Богино хугацаат	-74	-53	-73	21	29%	-21	-39%
4.2.3.4.2 Урт хугацаат	-50	5	-242	55	110%	-247	-4821%
4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	-74	-34	33	41	55%	67	199%
4.2.5.1 Богино хугацаат	-62	-34	33	29	46%	67	199%
4.2.5.2 Урт хугацаат	-12	0	0	12		0	
4.2.6 Бусад авлага	0	6	0	6		-6	
4.2.7 Зээлжих тусгай эрх	0	0	0	0		0	
IV. Алдаа болон орхигдуулга	23	144	138	121	5	-6	0
V. НООЦ ХӨРӨНГӨ	214	1,258	334	1,044	488%	-924	-73%
1. ГВУН	214	1,337	370	1,123		-967	
2. ОУВС-гийн зээл	0	79	36	79		-43	
3. Тусгай санхүүжилт	0	0	0	0		0	

* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.

ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2015	12/31/2016	12/31/2017	3/31/2018	6/30/2018	9/30/2018	12/31/2018
Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц	(28,632)	(29,353)	(32,031)	(32,592)	(32,679)	(33,103)	(33,374)
Актив	3,907	4,309	5,553	5,684	5,621	5,428	6,204
Шууд хөрөнгө оруулалт	440	455	495	501	502	508	521
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	366	380	427	437	440	445	456
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	366	380	427	437	440	445	456
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
Өрийн хэргэсэл	73	75	68	64	62	63	66
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	72	75	68	63	61	62	65
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	1	1	1	1	1	1	1
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
үүнээс: Өрийн бичиг	0	0	0	0	0	0	0
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	0	0	0	0	0	0	0
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
Багийн хөрөнгө оруулалт	223	280	268	274	279	290	294
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	213	259	254	260	263	273	283
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	3	3	18	28	29	21	23
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	210	256	236	232	234	253	260
Бусад санхүүгийн байгууллага	163	165	168	176	189	197	214
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	47	91	69	3	45	56	46
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0	0	0
Бүртгэлтэй	0	0	0	0	0	0	0
Бүртгэлгүй	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
Өрийн бичиг	10	21	14	14	17	17	11
Төв банк	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	6	17	6	6	6	6	7
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	6	17	6	6	6	6	7
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	4	4	8	8	10	10	4
Богино хугацаат	0	0	1	1	3	3	4
Урт хугацаат	4	4	7	7	8	8	0
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	1	1	2	3	4
Урт хугацаат	4	4	7	7	1	8	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион	114	100	(0)	6	6	0	0
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	114	100	(0)	6	6	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	0
Бусад санхүүгийн байгууллагууд	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0
Опцион	0	0	0	0	0	0	0
Форвард хэлбэрийн хэлцлүүд	0	0	0	0	0	0	0
Ажилчдын хувьцааны опцион	0	0	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	1,807	2,178	1,782	1,920	1,844	1,735	1,846
Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	1,443	1,746	1,328	1,547	1,473	1,353	1,362
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	441	762	461	605	643	532	461
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	1,002	984	867	943	830	820	901
Зээл	50	62	61	60	60	60	150
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	49	61	60	60	60	60	150
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	1	1	2	(0)	0	0	(0)
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	314	370	392	313	310	322	334
Бусад дансны авлага/өглөг	0	0	0	0	0	0	0
Нөөц хөрөнгө	1,323	1,296	3,008	2,983	2,989	2,894	3,542

Үргэлжлэл.

Гадаад пассив	32,539	33,662	37,584	38,276	38,300	38,531	39,578
Шууд хөрөнгө оруулалт	20,696	16,277	18,020	18,520	18,969	19,379	19,956
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	9,575	8,851	10,023	10,286	10,525	10,540	10,759
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч							
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
үүнээс: Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
Өрийн хэрэгсэл	11,121	7,426	7,996	8,234	8,443	8,840	9,197
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	11,121	7,426	7,996	8,234	8,443	8,840	9,197
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
Багцын хөрөнгө оруулалт	3,067	3,631	4,937	4,759	4,360	4,503	4,884
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	80	71	71	71	69	79	75
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	11	11	11	11	11	21	21
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	69	60	60	60	58	58	54
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0	0	0
Бүртгэлтэй	0	0	0	0	0	0	0
Бүртгэлгүй	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
Өрийн бичиг	2,987	3,560	4,866	4,687	4,291	4,424	4,809
Төв банк	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	652	611	589	608	593	629	621
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	652	611	589	608	593	629	621
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	1,473	2,064	3,549	3,340	2,981	3,068	2,947
Богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Урт хугацаат	1,473	2,064	3,549	3,340	2,981	3,068	2,947
Бусад салбарууд	862	886	728	738	717	727	1,241
Богино хугацаат	2	2	2	2	2	2	2
Урт хугацаат	860	884	726	736	715	725	1,239
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион	166	116	(0)	6	25	1	1
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	166	116	(0)	6	25	1	1
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	8,610	13,638	14,628	14,992	14,947	14,648	14,738
Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	1,954	1,965	2,245	2,365	2,210	2,101	2,123
Төв банк	1,772	1,725	1,837	1,913	1,811	1,744	1,745
Богино хугацаат	1,772	1,725	1,837	1,913	1,811	1,744	1,745
Урт хугацаат	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	182	240	314	330	297	317	327
Богино хугацаат	0	0	314	330	297	317	327
Урт хугацаат	182	240	0	0	0	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	95	122	102	40	51
Зээл	6,398	11,457	12,102	12,354	12,395	12,237	12,241
Төв банк	68	65	188	224	253	252	286
ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс бусад)	68	65	188	224	253	252	286
Бусад богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Бусад урт хугацаат	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	1,294	1,567	1,291	1,408	1,410	1,352	1,272
Богино хугацаат	407	469	345	439	472	453	430
Урт хугацаат	887	1,098	946	970	938	900	842
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	2,287	2,805	3,772	3,902	3,933	3,956	4,236
ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0
Бусад богино хугацаат	0	0	0	0	0	0	0
Бусад урт хугацаат	2,287	2,805	3,772	3,902	3,933	3,956	4,236
Бусад салбарууд	2,749	7,020	6,850	6,820	6,799	6,677	6,447
Богино хугацаат	260	218	292	266	271	252	243
Урт хугацаат	2,489	6,802	6,558	6,554	6,528	6,425	6,204
Бусад санхүүгийн байгууллага	0	0	529	0	0	0	287
Богино хугацаат	0	0	41	0	0	0	44
Урт хугацаат	0	0	487	0	0	0	243
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	2,749	7,020	6,322	170	6,799	6,677	6,160
Богино хугацаат	260	218	251	83	271	252	199
Урт хугацаат	2,489	6,802	6,071	87	6,528	6,425	5,961
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	138	216	280	274	341	310	374
Бусад дансны авлага/өглөө	120	0	0	0	0	0	0

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/30/2016	12/31/2017	3/31/2018	6/30/2018	9/30/2018	12/31/2018
Засгийн газар	4,868,606.40	7,320,975.43	7,242,453.24	6,914,505.40	7,023,656.38	7,182,508.57
Богино хугацаат	-	-	-	-	-	-
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
Ург хугацаат	4,868,606	7,320,975	7,242,453	6,914,505	7,023,656	7,182,509
Зээлжих ту сгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/	-	-	-	-	-	-
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	2,063,528	3,548,542	3,340,397	2,981,197	3,067,881	2,946,589
Зээл	2,805,078	3,772,434	3,902,056	3,933,308	3,955,775	4,235,920
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
Төвбанк	1,790,751.38	2,025,079.22	2,136,577.02	2,064,702.76	1,995,912.18	2,030,221.70
Богино хугацаат	1,725,434	1,837,133	1,912,712	1,811,484	1,743,626	1,744,562
Харилцах, хадгаламж 5/	1,725,434	1,837,133	1,912,712	1,811,484	1,743,626	1,744,562
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
Ург хугацаат	65,317	187,946	223,865	253,218	252,286	285,660
Зээлжих ту сгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/	65,317	187,946	223,864	253,218	252,286	285,660
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	2,417,380.34	2,194,264.37	2,346,483.06	2,299,838.41	2,298,667.68	2,220,219.91
Богино хугацаат	469,093	659,008	768,589	769,092	769,567	757,185
Харилцах, хадгаламж 5/	-	313,669	330,056	296,720	316,964	326,765
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-
Зээл	469,093	345,339	438,533	472,371	452,603	430,420
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
Ург хугацаат	1,948,288	1,535,256	1,577,894	1,530,747	1,529,101	1,463,035
Харилцах, хадгаламж 5/	239,612	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	611,048	589,222	608,281	593,036	629,465	621,108
Зээл	1,097,628	946,034	969,613	937,711	899,636	841,927
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
Бусад салбарууд	8,121,485.23	7,955,844.24	7,953,522.29	7,958,650.57	7,753,433.66	8,113,613.34
Богино хугацаат	394,395	666,472	656,486	642,216	529,478	596,581
Харилцах, хадгаламж 5/	-	94,606	121,945	101,945	40,009	51,278
Өрийн бичиг 4/	2,120	2,120	2,120	2,120	2,120	2,099
Зээл	217,529	292,414	266,008	270,955	251,535	243,005
Худалдааны зээл болон урьдчилгаа	174,746	277,332	266,413	267,197	235,815	300,199
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
Ург хугацаат	7,727,090	7,289,372	7,297,036	7,316,435	7,223,955	7,517,032
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	883,672	726,032	736,312	714,658	724,600	1,238,953
Зээл	6,801,973	6,560,413	6,553,606	6,527,658	6,425,237	6,203,961
Худалдааны зээл болон урьдчилгаа	41,445	2,927	7,118	74,118	74,118	74,118
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	7,426,276.86	7,996,493.58	8,233,582.34	8,443,293.91	8,839,583.79	9,196,525.93
Шууд хөрөнгө оруулагчид өгөх өглөг	7,426,277	7,996,494	8,233,582	8,443,294	8,839,584	9,196,526
Шууд хөрөнгө оруулагчийн өгөх өглөг	-	-	-	-	-	-
Хамааралтай компани хоорондын өглөг	-	-	-	-	-	-
Нийт гадаад өр	24,624,500.22	27,492,656.85	27,912,616.96	27,680,991.05	27,911,253.68	28,743,089.44